

ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Д.ЗОЛБООГИЙН ХЭЛСЭН ҮГ

Бидний урилгыг хүлээн авч, хүндэтгэн хүрэлцэн ирсэн эрдэмтэн та бүхний өглөөний амар амгаланг айлтгая. Эдүгээгээс 70 гаруй жилийн тэртээ дэлхийн II дайны дараа олон улсын харилцаанд шинэ нөхцөл байдал үүсэж, улс хоорондын харилцаа үндсээрээ өөрчлөгдсөн үеийн дараа 1949 онд Хятад улсад ардын хувьсгал ялж, шинэ Хятад улс байгуулагдсан билээ. БНМАУ нь урд хөрш болох БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосноор олон мянган жилийн турш айл хөрш оршиж, түүхэн янз бүрийн цаг үеийг туулсан Монгол-Хятадын ард түмний харилцааны цоо шинэ үе эхэлсэн. Эрх баригч МАХН-аар удирдуулсан БНМАУ-ын Засгийн газар, ХКН-аар удирдуулсан БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцаа шинэ агуулгатай эрх тэгш, улс хоорондын харилцааны үндсэн дээр хөгжих болсон билээ. Энэхүү харилцааны эхлэл нь хоёр улсын хоорондох анхны хэлэлцээр болох эдийн засаг, соёлын хэлэлцээрээр баталгаажсан байдаг. БНМАУ-ын СнЗ-ийн дарга Юмжаагийн Цэдэнбал 1952 оны 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 7-ны өдрийг хүртэл БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн нь анхны гадаад орны засгийн газрын тэргүүний айлчлал болж, тус улсын дипломатын түүхэнд үлдсэн билээ. Энэхүү айлчлалын үеэр буюу 10 дугаар сарын 4-нд хоёр улсын Засгийн газар хоорондын анхны хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоёр улсын харилцаа, тэр дундаа эдийн засаг, соёлын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой болсон байна. Энэхүү хэлэлцээрт тулгуурлан хоёр улс жил болгоны Монгол-Хятадын хооронд бараа харилцан нийлүүлэх тухай протоколууд, Соёлын хамтын ажиллагааны төлөвлөгөөнүүдийг байгуулсан нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжлийг нээсэн чухал ач холбогдолтой үйл явдлууд байсан юм. Ийнхүү хоёр улсын хооронд эдийн засаг, соёлын хэлэлцээр байгуулагдсаны түүхт 70 жилийн ойг тохиолдуулан манай хүрээлэнгээс санаачлан энэхүү Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна. Мөн ч 70 жилийн түүхэнд анх удаа Эрдэм шинжилгээний бага хурлын хүрээнд тус хэлэлцээрийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байгаа явдал болно. Үүнд бид баяртай байна. Өнөөдрийн энэхүү хуралд 1952 оноос хойш хоёр улсын хооронд байгуулагдсан хэлэлцээрийн түүхэн цаг үе, түүнээс хойших замнал, хувьсал, Монгол, Хятадын харилцаанд гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг үнэлж дүгнэхээс гадна баримт бичгийн шинж чанар, хэлбэр агуулгыг ч хөндсөн өргөн цараатай асуудлыг хамран хэлэлцэнэ хэмээн бодож байна.

Энэхүү Эрдэм шинжилгээний хуралд оролцогч эрхэм та бүхэн үзэл бодол, үнэлэлт дүгнэлт, санал бодлоо чөлөөтэй уралдуулж, гадаад бодлогын үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндсийг цааш боловсронгуй болгох, улмаар гадаад бодлогын сэтгэлгээг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Анхаарал хандуулсан та бүгдэд баярлалаа.